



БАЯНХОНГОР АЙМГИЙН
БУУЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 31 өдөр

Дугаар 317

Буянт

Г М.Саранчимэгийг ажлаас чөлөөлөх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.22, Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дахь зүйлийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байгаа Мандахын Саранчимэгийг 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.

2.Тамгын газрын даргын ажлыг хүлээлцэх ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: М.Түвшинсайхан (Хууль, эрх зүйн мэргэжилтэн)

Гишүүдэд: Б.Золзаяа (Санхүү албаны дарга)

А.Отгонцэцэг (Нягтлан бодогч)

Ц.Долгормаа (Архив, бичиг хэргийн эрхлэгч)

М.Жаргалсайхан (Нярав)

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч дарга (Г.Пэрэнлэй)-д даалгасугай.

ДАРГА



Х.ДАГВАДОРЖ

642401243



БАЯНХОНГОР АЙМГИЙН
БУУЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 5/16

Буянт

Г Нэг удаагийн тэтгэмж олгох тухай Г

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Хамтын гэрээний 3 дугаар зүйлийн 3.12 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын Засаг даргын Тамгын газрын Тэмээт 1р багийн Засаг дарга Д.Баттогтох-д 100,000 (Зуун мянга), Баян 2р багийн Засаг дарга С.Батзориг-т 100,000 (Зуун мянга), Өлзийт 3р багийн Засаг дарга Б.Батсүх-д 100,000 (Зуун мянга), Баянбүрд 4р багийн Засаг дарга П.Сайнбилэг-т 100,000 (Зуун мянга), Наран 5р багийн Засаг дарга Х.Энхтайван-д 100,000 (Зуун мянга), Буянт 6р багийн Засаг дарга Ш.Батсүх-д 100,000 (Зуун мянга) төгрөг, нийт 600,000 (Зургаан зуун мянга) төгрөгийн нэг удаагийн тэтгэмж урамшуулал олгосугай.

2.Дээрх зардлыг Засаг даргын тамгын газрын зөвшөөрөгдсөн төсвөөс санхүүжүүлэхийг Нягтлан бодогч (А.Отгонцэцэг)-т зөвшөөрсүгэй.

3.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн албаны дарга (Б.Золзаяа)-д даалгасугай.

ДАРГА



Х.ДАГВАДОРЖ

642401229



БАЯНХОНГОР АЙМГИЙН
БУУЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 5115

Буянт

С. Мөнхтогоод үр дүнгийн
урамшуулал олгох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.5, 59.123, Төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4.2, "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам батлах" тухай Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2 дугаар зүйлийн 2.1, 2.2, 2.3, дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Соёлын төвийн дарга ажилтай Сосорбарамын Мөнхтогоод 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний бүтэн жилийн биелэлт, сумын Засаг дарга, Соёл урлаг аялал жуулчлал, залуудын газрын дарга, Соёлын төвийн дарга нарын хамтран ажиллахаар байгуулсан гэрээний биелэлтийн хэрэгжилтийг үндэслэн ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг бодож олгосугай.

2.С.Мөнхтогоод ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг 25 хувиар тооцон 12 дугаар сарын цалинд бодож олгохыг Нягтлан бодогч (А.Отгонцэцэг)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү албаны дарга (Б. Золзаяа)-д даалгасугай.

ДАРГА



Х. ДАГВАДОРЖ

642401213